



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 11 өдөр

Дугаар 8/467

Арвайхээр сум

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйл, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.12 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт орсон их хэмжээний аадар борооноос үүссэн үерийн аюулын улмаас учирсан хор уршигт дүн шинжилгээ хийх, учирсан хохирлыг арилгах, сэргээн босгох ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий Ерөнхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Үерийн аюулын улмаас учирсан хор уршигт үнэлгээ тогтоох үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Мэргэжлийн үнэлгээчин, төсөвчнийг татан оролцуулж, тооцооллыг бодитоор гаргаж ажиллахыг Үнэлгээ тогтоох ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т даалгасугай:

4.Энэ захирамжийн 1, 2 дугаар зүйлд заасан ажлыг “Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам”-д заасан хугацаанд багтаан зохион байгуулж, дүн мэдээг Улсын Онцгой комисст хүргүүлж, ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ

И.ДОРЖСҮРЭН



Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дугаар  
сарын 11-ны өдрийн 11:00 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт

**ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**



Ажлын хэсгийн ахлагч: Ц.Идэрсайхан (аймгийн Засан даргын Тамгын газрын  
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Гишүүд:

Б.Цогтбаатар (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын  
хэлтсийн Авто замын хяналтын улсын байцаагч)

С.Нямдорж (аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг  
Барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн  
хяналтын ахлах байцаагч)

Г.Балжинням (аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний  
агентлаг Онцгой байдлын Гамшигаас хамгаалах улсын  
хяналтын ахлах байцаагч, хошууч)

Б.Сэргэлэнбаатар (аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний  
агентлаг Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн  
удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн,  
ахлах дэслэгч)

Э.Мягмардорж (аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний  
агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын  
байгаль орчны хяналтын улсын байцаагч)

С.Ганчимэг (Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын  
дарга)

Б.Батбаяр (аймгийн "АЗЗА" ТӨХК-ний Ерөнхий инженер)

Б.Даваадагва (Онги-Ус суваг ОНӨААТҮ-ний газрын Ерөнхий  
инженер)

Б.Гантулга (Цаг, уур орчны шинжилгээний төвийн хэлтсийн  
дарга)

(Барилга болон зам, гүүрийн мэргэжлийн төсөвчин)  
(зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга : Ц.Нямдалай (аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний  
агентлаг Барилга, хот байгуулалтын газрын барилгын  
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2023 оны 9<sup>дугаар</sup>  
сарын 1<sup>-ны өдрийн</sup> 9<sup>дугаар</sup>  
захирамжийн 1 дүгээр хавсралт

ЕРӨНХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Д.Одонбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа)

Ч.Гүнсэнхорол (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Г.Баясгалан (аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга)

Д.Лхам-Оролмаа (аймгийн “АЗЗА” ТӨХК-ний гүйцэтгэх захирал)

Ц.Хоролсүрэн (Онги-Ус суваг ОНӨААТҮ-ний газрын захирал)

Б.Дэмбэрэлсайхан (“ЭБЦТС” ТӨХК-ний салбарын дарга)

Ч.Чанцалдиймаа (Цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга)

Б.Ганбат (Арвайхээр сумын Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Т.Ариунболд (аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг Барилга, хот байгуулалтын газрын дарга)